



ГЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН БИЕЙИН
ТАМИР, СПОРТЫН ТӨВИЙН
МЕНЕЖЕР Г.ПҮРЭВ ТАНАА

ҮНДСНИЙ АУДИТИН ГАЗРЫН ХАРЬЯА
ДУНДГОВЬ АЙМГИЙН
АУДИТИН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

48090 Дундговь аймаг,
Сайнцагаан сум, Нарлаг баг
Утас: 70-59-24-39, 70-59-22-08, 70-59-32-08
E-mail: dundgovi@audit.gov.mn

2017. 02.13 № 01/НУ ДУА-2017/Н2У/СТА-ТШЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд аймгийн Аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Эрдэнэдалай сумын Биеийн тамир, спортын төвийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар үндсэн цалингийн зардлын төсвөөс гэрээт ажилтнуудыг цалинжуулж, нийт 5,225,124 /Таван сая хоёр зуун хорин таван мянга нэг зуун хорин дөрөв/ төгрөг зарцуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д /батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах/, Сангийн сайдын 2014 оны 03 дугаар сарын 14-ний 55 дугаар тушаалын 6 дугаар хавсралтаар батлагдсан “Төсвийн зарлагын эдийн застгийн ангиллыг ашиглах заавар”-ын үндсэн цалингийн тайлбар хэсэгт /цалингийн сүлжээ болон бусад холбогдох эрх зүйн актын дагуу тогтоон олгож байгаа албан тушаалын үндсэн цалин энэ ангилалд багтана./гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад шэрсэн толбор, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронеуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжсээч, аудитор, шинжсээч нь аудитын явцад илэрсэн толборийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор толборийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.3-д /Төсвийн хөрөнгийг ур ашиггүй, зориулаалт бусаар, батлагдсан хэмжээнээс хэтрүүлэн зарцуулж, Төсвийн тухай хуулийн холбогдох зүйл заалтыг зөрчсөн / гэж заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Үндсэн цалингийн зардлын төсвөөс гэрээт ажилтнуудыг цалинжуулахгүй байх, цаашид батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх.

000000028

2. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг аймгийн Аудитын газарт 2017 оны 04 дүгээр сарын 25-ны дотор ирүүлэхийг Эрдэнэдалай сумын Биеийн тамир, спортын төвийн менежер /Г.Пүрэв/, нягтлан бодогч /Д.Ууганбаяр/ нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН¹:

Ахлах шинжээч



Ч.Бэрхсайхан

Менежер

Нягтлан бодогч

ЗӨВШӨӨРСӨН:

Монгол Улсын Тамжийн Спортын Аудитын ТСД

Г.Пүрэв

Д.Ууганбаяр

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.